



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨААТҮГ-ЫН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/03/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Ахлах аудитор: А.Даваадорж
Утас: 261740 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Аудитор: Г.Мөнхчимэг
Утас: 261740 Цахим хаяг: munkhchimegg@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	12
6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
7. Аудитын илрүүлэлт	14
7.1 Залруулсан алдаа	14
7.2 Төлбөрийн акт.....	14
7.3 Албан шаардлага	14
7.4 Зөвлөмж	15
8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгал орчин, аялал жуулчлалын яам
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН
ТӨВ ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
С.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

2022.03.15 № 07/553
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартад бүрэн нийцээгүй, материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө материаллаг бөгөөд түгээмэл тархсан байна. Үүнд:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтээс 117.0 сая төгрөгийн өр төлбөр барагдуулж, 48.3 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 288.4 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гаргаж, нийт 453.7 сая төгрөгийн гэрээг дүгнээгүй, тайлант онд хэрэгжүүлээгүй төсөл, арга хэмжээний 290.5 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй зэрэг нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 45 дугаар зүйлийн 45.2, 45.2.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бидний олж авсан аудитын нотолгоо аудитын сөрөг дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

Асуудлыг онцолсон зүйл

Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ нь Улсын Их Хурал, Засгийн газар, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гаргасан

аялал жуулчлалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах чиг үүрэг бүхий салбарын хөгжлийг олон улсын жишигт нийцүүлэх маш чухал байгууллага гэж үзэж байна. Харьгалах яам, төрийн захиргаа удирдлагын газраас байгууллагын дүрэмд заасан үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлэхэд нь анхаарч, дэмжлэг үзүүлж ажиллах шаардлага байна.

Аудитын гол асуудлууд

Тус байгууллагын удирдлага тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, холбогдох засгийн газрын тогтоол, сайдын тушаалыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Бусад асуудал

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөллөөс шалтгаалсан аялал жуулчлалын салбарын уналт нь тус байгууллагын үйл ажиллагааны өсөлтөд сөрөг нөлөө үзүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	300,934,394.63	1,179,452,144.88
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,901,838.22	290,520,340.39
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	40,930.00	2,280,775.57
31110	Төгрөг	40,930.00	2,280,775.57
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,860,908.22	288,239,564.82
31210	Төгрөг	4,860,908.22	288,239,564.82
31213	Арилжааны банк дахь харилцах	4,860,908.22	288,239,564.82
33	АВЛАГА	4,904,650.00	9,227,950.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,904,650.00	9,227,950.00
34	УРЬДЧИЛГАА	289,257,407.41	879,352,654.49
34600	Урьдчилж гарсан зардал	289,257,407.41	879,352,654.49
35	БАРАА МАТЕРИАЛ	1,870,499.00	351,200.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,870,499.00	351,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	72,791,417.00	104,446,363.76
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	72,791,417.00	104,446,363.76
39200	Биет хөрөнгө	71,999,417.00	103,350,413.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,100,000.00	34,100,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,705,000.00)	(5,115,000.04)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	30,645,430.00	58,423,430.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,168,408.00)	(19,224,296.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,496,610.00	21,071,210.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(679,215.00)	(2,434,929.30)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,500,000.00	17,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(190,000.00)	(970,000.03)
39300	Биет бус хөрөнгө	792,000.00	1,095,950.04
39303	Бусад биет бус хөрөнгө	880,000.00	1,282,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(88,000.00)	(186,049.96)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	373,725,811.63	1,283,898,508.64
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	520,915,917.96	1,648,534,691.97
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	520,915,917.96	1,648,534,691.97
41300	Өглөг	157,040,817.96	49,959,713.32
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	45,361,622.65	15,714,118.85
41350	Зээлийн хүүгийн өглөг	-	1,050,000.00
41360	Бусад өглөг	111,679,195.31	33,195,594.47
41361	Байгууллагад төлөх өглөг	34,783,444.21	4,401,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	48,169,241.00	20,455,795.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	8,707,913.00	7,727,396.26
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	20,018,597.10	611,403.21
41400	Урьдчилж орсон орлого	363,875,100.00	1,598,574,978.65
41440	Бусад урьдчилж орсон орлого	363,875,100.00	1,598,574,978.65
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	(147,190,106.33)	(364,636,183.33)
51	Засгийн газрын хувь оролцоо	(147,190,106.33)	(364,636,183.33)
51200	Хуримтлагдсан үр дүн	(147,190,106.33)	(364,636,183.33)
51210	Өмнөх үеийн үр дүн	405,615.00	(121,457,172.27)
51220	Тайлант үеийн үр дүн	(147,595,721.33)	(243,179,011.06)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	373,725,811.63	1,283,898,508.64

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	33,232,190.00	99,640,180.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,232,190.00	99,640,180.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,232,190.00	99,640,180.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	91,288,800.00	335,120,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	91,288,800.00	335,120,000.00
120009	Бусад орлого	315,000.00	-
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	58,371,610.00	235,479,820.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	180,827,911.33	342,819,191.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	180,827,911.33	342,819,191.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	180,827,911.33	342,819,191.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	117,691,461.00	181,869,852.51
210101	Үндсэн цалин	117,691,461.00	181,869,852.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,169,150.00	22,886,732.80
210201	Тэтгэврийн даатгал	14,169,150.00	22,886,732.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,358,252.00	23,600,632.00
210304	Байрны түрээс	3,358,252.00	23,600,632.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,315,677.00	55,050,104.90
210401	Бичиг хэрэг	1,490,257.00	6,155,696.00
210402	Тээвэр, шатахуун	3,799,176.00	6,622,947.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,026,244.00	8,650,292.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	12,831,367.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	20,789,802.00
2107	Томилолт, зочны зардал	10,166,021.00	-
210701	Гадаад албан томилолт	10,166,021.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,618,727.33	42,312,215.61
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	5,540,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,953,200.00	-
210813	Бусад зардал /ТӨҮГ/	11,665,527.33	36,772,215.61
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,508,623.00	17,099,653.24
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,508,623.00	17,099,653.24
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(147,595,721.33)	(243,179,011.06)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(147,595,721.33)	(243,179,011.06)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	405,615.00	405,615.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	405,615.00	405,615.00
Тайлант үеийн үр дүн	-	-	(147,595,721.33)	(147,595,721.33)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	(147,190,106.33)	(147,190,106.33)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	25,732,934.06	25,732,934.06
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(121,457,172.27)	(121,457,172.27)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(243,179,011.06)	(243,179,011.06)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	(364,636,183.33)	(364,636,183.33)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	91,603,800.00	1,565,496,873.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	91,603,800.00	1,565,496,873.00
120	Нийтлэг татварын бус орлого	91,603,800.00	1,565,496,873.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	91,603,800.00	1,565,496,873.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	454,335,428.06	1,237,123,770.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	454,335,428.06	1,237,123,770.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	454,335,428.06	1,237,123,770.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	72,329,838.00	181,869,852.51
210101	Үндсэн цалин	72,329,838.00	181,869,852.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,844,803.00	22,886,732.80
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	7,844,803.00	22,886,732.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	23,600,632.00
210304	Байрны түрээс	-	23,600,632.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,946,822.00	34,260,302.90
210401	Бичиг хэрэг	-	6,155,696.00
210402	Тээвэр, шатахуун	4,946,822.00	6,622,947.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	8,650,292.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	12,831,367.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	369,213,965.06	974,506,250.62
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	5,814,976.00	-
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	363,398,989.06	974,506,250.62
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(362,731,628.06)	328,373,102.17
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	79,522,040.00	48,754,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	79,522,040.00	48,754,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	79,522,040.00	48,754,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	79,522,040.00	48,754,600.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(79,522,040.00)	(48,754,600.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	20,000,000.00	6,000,000.00
14	Бусад эх үүсвэр	20,000,000.00	153,200,000.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	20,000,000.00	153,200,000.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	147,200,000.00
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө	-	147,200,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(422,253,668.06)	285,618,502.17
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	427,155,506.28	4,901,838.22
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,901,838.22	290,520,340.39

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	мян.төг	633,683.8	1,760,347.0	335,120.0	1,425,227.0	19.0
1.1	Эрх шилжүүлэх ажлын орлого	мян.төг	633,683.8	1,760,347.0	335,120.0	1,425,227.0	19.0
1.2	Хураамжийн орлого	мян.төг	-	-	-	-	
2	Нийт зардал	мян.төг	622,850.7	1,725,104.8	578,299.0	1,146,805.8	33.5
2.1	Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	20,102.9	72,813.6	59,162.6	13,651.0	81.3
3	Татварын өмнөх ашиг	мян.төг	10,833.1	35,242.2	(243,179.0)	(207,936.8)	(690.0)
4	Цэвэр ашиг	мян.төг	9,749.8	31,718.0	(243,179.0)	(211,461.0)	(766.7)
5	Төсвийн нийт төлбөр	мян.төг	32,072.1	81,191.2	78,900.0	2,291.2	97.2
6	Ногдол ашигт	мян.төг	1,462.5	4,757.7	-	4,757.7	-
7	Нийт ажиллагсдын тоо	мян.төг	7	12	12	-	100.0
8	Нийт цалингийн сан	мян.төг	117,790.3	214,990.0	204,756.6	10,233.4	95.2
9	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	1,209.2	1,492.9	1,411.6	81.3	94.6
10	Хөрөнгө оруулалт	мян.төг	70,650.8	41,895.0	36,154.6	5,740.4	86.3
11	Нийт авлага	мян.төг	4,904.4	4,904.4	9,227.9	(4,323.5)	188.2
12	Нийт өглөг	мян.төг	157,040.8	157,040.8	49,348.3	107,692.5	31.4

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэлийн бодлого, мөнгөн хөрөнгө, санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 5-наас 2022 оны 3 дугаар сарын 10-ны хооронд Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор Г.Мөнхчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 22/29 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Байгууллагын захирал Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан эрх, үүргээ, ерөнхий нягтлан бодогч Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Гүйцэтгэх захирлын 2020 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн А/22 дугаар бүхий тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт байгууллагын онцлог болох эрх шилжүүлэх гэрээний дагуу бий болсон орлого, кассын бүртгэл болон бусад дагаж мөрдөх хууль, тогтоомж, стандартын талаар бүрэн тусгаагүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хэрэгжүүлдэг ба тайлант жил аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар хувиар буюу 2.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын зорилго нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, "Алсын хараа-2050" бодлогод тулгуурласан, олон талын оролцоог хангасан, олон улсын стандартын түвшинд хүрсэн өрсөлдөх чадвар бүхий мэргэшсэн байгууллага байхад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсыг гадаад, дотоодод нэгдсэн байдлаар сурталчлах ажлыг зохион байгуулах;
- Гадаад улс орны ижил түвшний байгууллагуудтай холбоо тогтоож хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Аялал жуулчлалын салбарт хүний нөөцийн хөгжлийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн төлөвлөн хэрэгжүүлэх;
- Аялал жуулчлалын байгууллагад ангиллын гэрчилгээ олгох;
- Дээд зэрэглэлийн зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох;
- Аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа явуулах жуулчны бааз, зочид буудал, амралт, рашаан сувиллын газрын нэгдсэн бүртгэл хөтлөх, аялал жуулчлалын мэдээллийн нэгдсэн сүлжээ, сан байгуулах;
- Аялал жуулчлалын статистик мэдээллийг нэгтгэж, судалгаа, дүн шинжилгээ хийх;
- Байгууллагын зорилго, зорилтод нийцсэн үйл ажиллагааг гадаад, дотоодын хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх;
- Улсын болон олон улсын хэмжээний өдөрлөг, арга хэмжээнүүдийг зохион байгуулах;
- Хуульд заасан бусад

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай байна. Өмчийг 100 хувь төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 02 дугаар "Аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулах тухай" тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө

хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,901.8	290,520.3	285,618.5
Авлага	4,904.7	9,227.9	4,323.2
Урьдчилгаа	289,257.4	879,352.7	590,095.3
Бараа материал	1,870.5	351.2	(1,519.3)
Үндсэн хөрөнгө	71,999.4	103,350.4	31,351.0
Биет бус хөрөнгө	792.0	1,096.0	304.0
Нийт хөрөнгийн дүн	373,725.8	1,283,898.5	910,172.7
Богино хугацаат өглөг	157,040.8	49,959.7	(107,081.1)
Урьдчилж орсон орлого	363,875.1	1,598,575.0	1,234,699.9
Эздийн өмч	(147,190.1)	(364,636.2)	(217,446.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	373,725.8	1,283,898.5	910,172.7

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 2.3 сая, банк дахь мөнгөний үлдэгдэл 288.2 сая төгрөг байгаа нь хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний зарцуулагдаагүй үлдэгдэл юм.

Тайлант онд “Аялал жуулчлалын хөтөлбөрийн зардлын хуваарь” батлах тухай БОАЖС-ын 2021 оны А/221, А/318 дугаар тушаалаар баталсан гэрээт ажлын төлбөрт 617.6 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна. Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2020 онд шилжүүлсэн 289.2 сая төгрөгийн ажлыг зориулалт бусаар зарцуулсан гэдэг шалтгаанаар эрх шилжүүлсэн байгууллагаас гүйцэтгэлийг хүлээн аваагүй байна. Урьдчилгаа данснаас тайлант онд ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 316.7 сая төгрөгийг зардлыг хүлээн зөвшөөрсөн байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл өссөн нь БОАЖЯ-аас аялал жуулчлалын хөтөлбөрийн 32 арга хэмжээнд зориулан 1,585.4 сая төгрөгийг эрх шилжүүлэн олгосонтой холбоотой байна. Тайлант онд 335.1 сая төгрөгийн урьдчилж орсон орлого хэрэгжсэн байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл -364.6 сая төгрөг болж 217.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны алдагдлаас шалтгаалжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2020 оны 648 дугаар тогтоолоор Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,760.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,725.1 сая төгрөгөөр, 31.7 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 41.9 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 335.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 578.3 сая төгрөгийн зардал гарган, 243.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 335.1 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,425.2 сая төгрөг буюу 81 хувиар тасарсан, нийт зардлын гүйцэтгэл 578.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,146.8 сая төгрөг буюу 66.5 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь БОАЖЯ-аас эрх шилжин ирсэн 32 арга хэмжээний 763.9 сая төгрөгийн 6 арга хэмжээ хэрэгжээгүй, 1,038.9 сая төгрөгийн 17 арга хэмжээ гүйцэтгэл бүрэн гараагүй зэргээс шалтгаалжээ.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ нь тайлант онд нийт 2,512.2 сая төгрөгийн 80 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 571.4 сая төгрөгийн 6 мэдээллийг байршуулаагүй, 406.0 сая төгрөгийн 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

БОАЖЯ-наас эрх олгоогүйгээс Аялал жуулчлалын хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 5.2.4 аялал жуулчлалын байгууллагад ангиллын гэрчилгээ олгох, 5.2.5 дээд зэрэглэлийн зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох үйл ажиллагаа хэрэгжихгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дүрэмд заасан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид тавьж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

БОАЖС-ын А/404 дугаар бүхий “Аялал жуулчлалын хөтөлбөрийн зардлын хуваарь”-т өөрчлөлт оруулах тушаал 2021 оны 12 дугаар сарын 21-нд гарч, Төрийн нарийн бичгийн даргатай “Ажил гүйцэтгэх гэрээ” шинэчлэн байгуулсан нь хуваарьт өөрчлөлт орсон ажлуудыг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант жилд гүйцэтгэх боломжгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулахгүй байх зөвлөмж өгөв.

Босго үнээс дээш төсөвт өртөгтэй 617.6 сая төгрөгийн 27 арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендер зарлалгүй шууд гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж, хуульд заасан босго үнээс дээш үнийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа тендер зарлан сонгон шалгаруулалт хийх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь судалгаа, шинжилгээнд үндэслээгүй, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй, хэт ерөнхий байдлаар хийгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт байгууллагын мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм, журам, тогтсон практикийг тусгах талаар зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн холбогдох заалттай нийцээгүй, ТӨБЗГ-аас баталсан байгууллагын дүрэм бүрэн хэрэгжихгүй байна гэж дүгнэлээ.

6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ нь Улсын Их Хурал, Засгийн газар, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гаргасан аялал жуулчлалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаж байгаа эсэхэд анхаарал хандуулах шаардлага байна.

7. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,436.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 294.0 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 290.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 805.5 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 46.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 1,142.6 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 2.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их, өргөн тархсан тул Сөрөг дүгнэлт өглөө.

7.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 294.0 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

- Борлуулалтын орлогыг 242.7 сая, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 4.7 сая төгрөгөөр илүү, ерөнхий ба удирдлагын зардлыг 8.7 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна;
- БОАЖС-ын тушаалаар эрх шилжүүлсэн арга хэмжээний 19.8 сая төгрөгийн гүйцэтгэлийг БОАЖЯам хүлээн зөвшөөрөөгүй байхад 2020 оны санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрсөн байна;
- Хөтөлбөр арга хэмжээний үр дүнд бий болсон 18.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.

7.2 Төлбөрийн акт

Тайлант онд хэрэгжүүлээгүй төсөл, арга хэмжээний 290.5 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”: 45.2.2 “төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант жил хэрэгжээгүй арга хэмжээний 290.5 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

7.3 Албан шаардлага

Санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанаас хоцроож 2022.03.03-ны өдөр Үндэсний аудитын газарт ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарт хугацааг мөрдөж ажиллах, дотоод хяналтыг сайжруулах талаар албан шаардлага өгөв.

Нийт орлогын гүйцэтгэл 81 хувиар тасарсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын дүрэмд заасан орлогын эх үүсвэр бий болгож, орлогыг нэмэгдүүлэх боломжийг судлах албан шаардлага өгөв.

Байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланд 50.0 сая төгрөгийн тооцоо нийлж, баталгаажуулаагүй өглөгийн үлдэгдэл бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийн үлдэгдлийг баталгаажуулах, барагдуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах албан шаардлага өгөв.

Албан конторын тавилга, бэлэг дурсгалын зүйлс худалдан авах, шагнал урамшуулал олгоход, зориулан 11.2 сая төгрөгийн зардал гаргасан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.3, 1.4 заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлыг хэмнэх, хөрөнгийг үр ашигтай зарцуулах, талаар албан шаардлага өгөв.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтээс 117.0 сая төгрөгийн өр төлбөр барагдуулж, 48.3 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 288.4 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гаргаж, нийт 453.7 сая төгрөгийн гэрээг дүгнээгүй, зардал хүлээн зөвшөөрөгдөөгүй байна.

Урьдчилж төлсөн зардал дансанд БОАЖС-ын 2019 оны А/314 тушаалаар эрх шилжүүлэн, хэрэгжиж дууссан арга хэмжээний 81.3 сая төгрөгийн зардлын үлдэгдэл бүртгэлтэй байгаа нь гэж заасантай нийцэхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Иргэний хуулийн 206 дугаар зүйлд "гэрээний талууд гэрээний үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөтөлбөр арга хэмжээний гүйцэтгэл, хүрсэн үр дүнг дүгнэж, гэрээнд заасан зардлыг санхүүжүүлэх албан шаардлага өгөв.

7.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллого хийгээгүй, хадгалалт, хамгаалалт хангалтгүй, элэгдлийн зардлыг 12.9 сая төгрөгөөр дутуу тооцоолсон зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", 70 дугаар зүйлийн 2-ын 1-д "үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/ хийнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүртгэл, тооцооллыг сайжруулж, тооллогыг жил бүрийн 12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор хийж, үр дүнг холбогдох байгууллагад хүргүүлж байх.

Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн зардлыг Нийгмийн даатгалын тайлан, ХХОАТ-ын тайлан болон санхүү үр дүнгийн тайланд 33.7 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2. Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг дахин шалгаж, Нийгмийн даатгалын хэлтэс болон харьяа татварын газартай тооцоо нийлж, холбогдох засварыг хийх.

Илрүүлэлт: Тайлант жил БОАЖС-ын эрх шилжүүлсэн арга хэмжээний мөнгөн хөрөнгийн зарлагын 17.8 хувь буюу 321.7 сая төгрөгийг кассын зарлага эзэлж байгаа нь Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 6.2-т “Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ (ЖМС) нь тухайн төсвийн байгууллагын жилийн батлагдсан төсвөөс (ЖБТ) хамааран дараах хэмжээтэй байна; ЖБТ 1,000,000,000 төгрөгөөс дээш - ЖМС 1,500,000- 3,000 000 төгрөг” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж, төрийн байгууллагаас эрх шилжүүлсэн арга хэмжээний мөнгөн зарлагыг харилцах дансаар дамжуулан гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ	Борлуулалтын орлогыг 242.7 сая, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 4.7 сая төгрөгөөр илүү, ерөнхий ба удирдлагын зардлыг 8.7 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.	Аудитын явцад залруулга хийв.	1	256,146.2	1	256,146.2						
2	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ	БОАЖС-ын тушаалаар эрх шилжүүлсэн арга хэмжээний 19.8 сая төгрөгийн гүйцэтгэлийг БОАЖЯам хүлээн зөвшөөрөөгүй байхад 2020 оны санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.	Аудитын явцад залруулга хийв.	1	19,767.8	1	19,767.8						
3	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ	Хөтөлбөр арга хэмжээний үр дүнд бий болсон 18.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.	Аудитын явцад залруулга хийв.	1	18,076.0	1	18,076.0						
4	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ	Тайлант онд хэрэгжүүлээгүй төсөл, арга хэмжээний 290.5 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	Тайлант жил хэрэгжээгүй арга хэмжээний 290.5 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх.	1	290,520.3			1	290,520.3				
5	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ	Санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанаас хоцроож 2022.03.03-ны өдөр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.	Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарт хугацааг мөрдөж ажиллах, дотоод хяналтыг сайжруулах.	1	-					1	-		

6	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ	Нийт орлогын гүйцэтгэл 81 хувиар тасарсан байна.	Байгууллагын дүрэмд заасан орлогын шинэ эх үүсвэр бий болгож, орлогыг нэмэгдүүлэх боломжийг судлах.	1	-					1	-		
7	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтээс 117.0 сая төгрөгийн өр төлбөр барагдуулж, 48.3 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 497.7 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гаргаж, нийт 663.0 сая төгрөгийн гэрээг дүгнээгүй, зардал хүлээн зөвшөөрөгдөөгүй байна. Урьдчилж төлсөн зардал дансанд БОАЖС-ын 2019 оны А/314 тушаалаар эрх шилжүүлэн, хэрэгжиж дууссан арга хэмжээний 81.3 сая төгрөгийн зардлын үлдэгдэл бүртгэлтэй байна.	Хөтөлбөр арга хэмжээний гүйцэтгэл, хүрсэн үр дүнг дүгнэж, БОАЖЯ-ны зөвшөөрлөөр зардлыг хүлээн зөвшөөрөх.	1	744,313.5					1	744,313.5		
8	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ	Байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланд 50.0 сая төгрөгийн тооцоо нийлж, баталгаажуулаагүй өглөгийн үлдэгдэл бүртгэлтэй байна.	Өр төлбөрийн үлдэгдлийг баталгаажуулах, барагдуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах.	1	49,959.7					1	49,959.7		
9	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ	ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол зөрчин албан конторын тавилга худалдан авах, шагнал урамшуулал олгох, бэлэг дурсгал худалдан авахад зориулан 11.2 сая төгрөгийн зардал гаргасан байна.	Төсвийн тухай хуулийн 10.1.7, 10.1.11-д заасныг тус тус үндэслэн төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төрөөс гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах.	1	11,244.5					1	11,244.5		

10	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ	Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллого хийгээгүй, хадгалалт, хамгаалалт хангалтгүй, элэгдлийн зардлыг 12.9 сая төгрөгөөр дутуу тооцоолсон байна.	Үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүртгэл, тооцооллыг сайжруулж, тооллогыг жил бүрийн 12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор хийж, үр дүнг холбогдох байгууллагад хүргүүлж байх.	1	12,897.4							1	12,897.4
11	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ	Цалингийн зардлыг Нийгмийн даатгалын тайлан, ХХОАТ-ын тайлан болон санхүү үр дүнгийн тайланд 33.7 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.	Байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг дахин шалгаж, Нийгмийн даатгалын хэлтэс болон харьяа татварын газартай тооцоо нийлж, холбогдох засварыг хийх.	1	33,709.7							1	33,709.7
12	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ	Тайлант жил БОАЖС-ын эрх шилжүүлсэн арга хэмжээний мөнгөн хөрөнгийн зарлагын 17.8 хувь буюу 321.7 сая төгрөгийг кассын зарлага эзэлж байна.	Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж, төрийн байгууллагаас эрх шилжүүлсэн арга хэмжээний мөнгөн зарлагыг харилцах дансаар дамжуулан гүйцэтгэж байх.	1	-							1	
ДҮН					12	1,436,635.1	3	293,990.0	1	290,520.3	5	805,517.7	3	46,607.1
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал														
1	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ	Тайлант онд нийт 2,512.2 сая төгрөгийн 80 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 571.4 сая төгрөгийн 6 мэдээллийг байршуулаагүй, 406.0 сая төгрөгийн 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах.	1	977,418.2							1	977,418.2

2	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ	БОАЖЯ-наас эрх олгоогүйгээс Аялал жуулчлалын хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 5.2.4 аялал жуулчлалын байгууллагад ангиллын гэрчилгээ олгох, 5.2.5 дээд зэрэглэлийн зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох үйл ажиллагаа хэрэгжихгүй байна.	Дүрэмд заасан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид тавьж шийдвэрлүүлэх.	1	-							1	-
3	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ	БОАЖС-ын А/404 дугаар бүхий "Аялал жуулчлалын хөтөлбөрийн зардлын хуваарь"-т өөрчлөлт оруулах тушаал 2021 оны 12 дугаар сарын 21-нд гарч, Төрийн нарийн бичгийн даргатай "Ажил гүйцэтгэх гэрээ" шинэчлэн байгуулсан нь хуваарьт өөрчлөлт орсон ажлуудыг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэсэн байна.	Тайлант жилд гүйцэтгэх боломжгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулахгүй байх.	1	-							1	-
4	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ	Босго үнээс дээш төсөвт өртөгтэй 617.6 сая төгрөгийн 27 арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулахдаа тендер зарлалгүй шууд гэрээ байгуулсан байна.	ТБОНӨХБАҮХАТ хуулийг мөрдөж, хуульд заасан босго үнээс дээш үнийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа тендер зарлан сонгон шалгаруулалт хийх.	1	617,613.6					1	617,613.6		
5	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ	Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь судалгаа, шинжилгээнд үндэслээгүй, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй, хэт ерөнхий байдлаар хийгдсэн байна.	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт байгууллагын мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм, журам, тогтсон практикийг тусгах.	1	-							1	-
ДҮН					5	1,595,031.8	-	-	-	-	1	617,613.6	4	977,418.2
НИЙТ ДҮН					17	3,031,666.9	3	293,990.0	1	290,520.3	6	1,423,131.3	7	1,024,025.3



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 64 /40140044

Улаанбаатар хот

401-20000000601 - СТД-ТӨБ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтын дагуу гүйцэтгэсэн Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд хэрэгжүүлээгүй төсөл, арга хэмжээний 290,520,340.39 төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.


Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2 "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгадагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тайлант жил хэрэгжээгүй арга хэмжээний 290,520,340.39/ Хоёр зуун ерэн сая таван зуун хорин мянган гурван зуун дөчин төгрөг гучин есөн мөнгө төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал С.Бат-Эрдэнэ, Нягтлан бодогч С.Байгалмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
А.ДАВААДОРЖ
Г.МӨНХЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 940 / 2022-03-15

Улаанбаатар хот

940-2022/03/15 - САА-ТЭБ

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтын дагуу гүйцэтгэсэн Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан цаглаварт хугацаанаас 11 хоногоор хоцроож ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд санхүүгийн тайланг бэлтгэж ирүүлээгүй нягтлан бодогч С.Байгалмаад сахилгын шийтгэл оногдуулж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал С.Бат-Эрдэнэ хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

(Signatures)

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
А.ДАВААДОРЖ
Г.МӨНХЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-32.Docx

0010801055



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 331 / 20170084

Улаанбаатар хот

ДАГ - 2022 / 25 / 140 - 018-7223

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтын дагуу гүйцэтгэсэн Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Нийт орлогын гүйцэтгэл 1,425,227.00 төгрөг буюу 81 хувиар тасарсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын дүрэмд заасан орлогын эх үүсвэр бий болгож, орлогыг нэмэгдүүлэх боломжийг судлах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал С.Бат-Эрдэнэ, Нягтлан бодогч С.Байгалмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
А.ДАВААДОРЖ
Г.МӨНХЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№

872 /1400/4

Улаанбаатар хот

805-2022/03/НХ-СӨА-795

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтын дагуу гүйцэтгэсэн Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланд 49,959,713.32 төгрөгийн тооцоо нийлж, баталгаажуулаагүй өглөгийн үлдэгдэл бүртгэлтэй байна.


Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өр төлбөрийн үлдэгдлийг баталгаажуулах, барагдуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал С.Бат-Эрдэнэ, Нягтлан бодогч С.Байгалмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
А.ДАВААДОРЖ
Г.МӨНХЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 213 / 40140074

Улаанбаатар хот

ХН-2022/03/15-018-2022

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтын дагуу гүйцэтгэсэн Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан конторын тавилга, бэлэг дурсгалын зүйлс худалдан авах, шагнал урамшуулал олгоход, зориулан 11,244,490.00 төгрөгийн зардал гаргасан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.3, 1.4 заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зардлыг хэмнэх, хөрөнгийг үр ашигтай зарцуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал С.Бат-Эрдэнэ, Нягтлан бодогч С.Байгалмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Б. Наранчимэг
А. Даваадорж
Г. Мөнхчимэг

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
А.ДАВААДОРЖ
Г.МӨНХЧИМЭГ

9006109
9019120496

[illegible]

[illegible]

[illegible]